



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 12


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийн 3.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн амд “Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ хийх журам”-ыг нэгдүгээр, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах насны ангиллыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амын бүртгэл судалгааг гарган, үзлэгийг орон нутагтаа зохион байгуулж тус журмын дагуу ажиллахыг Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080047

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 15 өдрийн
12 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ХҮН АМД “ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь хүн амыг насны бүлгээс хамааран халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлст өртөж өвчлөх, хожуу оношлогдон даамжирч хүндрэлд хүрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад хийгдэх халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү үзлэгийг анхан шатанд сум, өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад /нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, төв эмнэлэг гэх мэт/ илгээнэ.
- 1.3. Нийт хүн амд эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийхийн зэрэгцээ иргэдэд уг үзлэгийн ач холбогдол, халдварт бус өвчнийг эрт оношлох талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.
- 1.4. Эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж байгаатай холбогдуулан хамрагдсан үйлчлүүлэгч бүрийг эмчийн үзлэгийн бүртгэлд “ӨОУА-10”-ын дагуу Z код-ыг хэрэглэнэ.

Хоёр. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа

- 2.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн дагуу харъяа нутаг дэвсгэрийн хүн амын судалгааг өмнөх жилийн 12 сарын 10-ны дотор гарган, хүн амыг бүрэн хамруулна.
- 2.2. Үзлэг хийх эмч нарт сургалт зохион байгуулж, эмнэлзүйн удирдамж, стандартын дагуу ажиллана.
- 2.3. Эрт илрүүлгийн үзлэгт шаардлагатай эм, урвалж, тоног төхөөрөмжийн жагсаалт, бүртгэлийн маягтын нөөцийг тухайн оны эхний улиралд багтаан гаргана.
- 2.4. Эрт илрүүлгээр илэрсэн өөрчлөлттэй хүмүүсийг дараагийн шатлалд илгээхдээ анхан шатны үзлэгийн үр дүнг тодорхой бичин карт болон 13А маягтын баруун дээд өнцөгт “ЭРТ ИЛРҮҮЛЭГ” гэсэн тэмдэг тавьж өгнө.
- 2.5. Иргэнийг Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт хамруулсны дараа халдварт бус өвчний эрсдлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх, эмчилгээний дэглэм зэрэг зөвлөлгөө зөвлөмжийг картанд нарийвчлан бичиж, хяналт тавьж ажиллана.
- 2.6. Улирал тутам тухайн улиралд эрт илрүүлэг үзлэгт хамрагдаагүй иргэдийн шалтгааныг тодруулж, нөхөн хамруулах ажлыг дараа улиралд багтаан хийнэ.

2.7. Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг халдварт бус өвчний эрт илрүүлгийн тайлан ЭМТ-103, СМХ-1, СМУ-1, ХБӨЭИМ-1, ХБӨЭИМ-2 маягтаар тайлагнана.

Гурав. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа

3.1 Анхан шатны эрүүл мэндийн төвөөс ирсэн “ЭРТ ИЛРҮҮЛЭГ” тодотголтой өвчтнийг хүлээн авч стандарт, удирдамжийн дагуу түргэн шуурхай онош тодруулах, эмчлэх, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, 13Б маягтыг бөглөн өвчтнийг анхан шатны эрүүл мэндийн төвд буцаана.

3.2 Хэрэв оношийг цаашид тодруулах шаардлагатай бол дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

3.3 Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах иргэдийн хуваарийг сараар гаргаж, эмч нарын ажлын ачааллыг зохицуулж ажиллана.

3.4 Үзлэг зохион байгуулах эмч, кабинетийг тодорхойлж, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулна.

3.5 Эрт илрүүлэг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, эм урвалж, бүртгэл маягтын тооцоог өмнөх жилийн эхний хагаст гарган, шаардлагатай нөөцийг оны эхний улиралд багтаан бий болгоно.

3.6 Артерийн гипертензи, чихрийн шижингийн эргэн мэдээллийг батлагдсан онош, авсан арга хэмжээ, цаашид өгөх зөвлөмжийн хамт дотрын кабинетаас эмчлэгч эмчээр гарын үсэг зуруулан цаасан хэлбэрээр статистикт нэгтгэн мэдээлнэ.

3.7 Хавдар бүртгэгчээс хавдрын эрт илрүүлэгт хамрагдаж онош тодорсон болон эсийн өөрчлөлттэй иргэний мэдээллийг дээрхийн адил баталгаажуулан статистикт мэдээлнэ.

3.8 Эрт илрүүлгээр илэрсэн өвчлөлийг мэргэжлийн кабинетийн их эмч, анхан шатны эрүүл мэндийн төвтэй хамтран хянаж үр дүнг тооцон ажиллана.

3.9 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн эмч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, шаардлагатай мэргэжилтнүүдийг давтан сургах ажлыг зохион байгуулна.

3.10 Эрт илрүүлэг үзлэгийн тайланг сар бүрийн эцэст холбогдох Эрүүл мэндийн газартаа хүргүүлнэ.

3.11 Аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, хувь хүний эрт илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа өгч ажиллана.

Дөрөв. Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаа

4.1 Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг удирдлага, зохион байгуулалтаар хангах явцад хяналт тавьж ажиллана.

4.2 Эрт илрүүлэг үзлэгийн тайланг хүлээн авч нэгтгэн жил бүрийн эцэст нэгдсэн тайлан гаргана.

4.3 Эрт илрүүлэг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, бүртгэл маягт, хүний нөөцөд судалгаа хийж, жил бүрийн төсөвт суулгана.

4.4 Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн эрт илрүүлгийн эргэн мэдээллийг 7 хоногоор авч анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад эргэн мэдээлнэ.

4.5 Эрт илрүүлэг үзлэгийн мэдээллийн санг нэгтгэн, хяналт үнэлгээ хийж, анхаарах асуудлаар заавар зөвлөлгөө өгч ажиллана.

4.6 Эрт илрүүлэг үзлэгийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.


Тав. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үйл ажиллагаа

5.1 Аймаг, дүүргээс илгээсэн сэжигтэй тохиолдлыг нарийвчилсан оношлогоо, шинжилгээнд оруулж, оношийг баталгаажуулах, эмчилгээ хийж, эргэн мэдээлнэ.

5.3 Хүн амын дунд эрүүл мэндийн болон эрт илрүүлгийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

5.4 Мэргэжлийн эмч нарын багийг орон нутагт ажиллуулж, илрүүлгийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 15 өдрийн
12 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



Хүн амын Халдварт бус өвчний нас, насанд нь тохирсон эрт илрүүлэг үзлэг

Насны бүлэг	Хүйс	Тогтмол үзлэг шинжилгээ	Давтамж
18-29 нас	Эр, эм	Цусны даралт, бие махбодийн үзүүлэлт, БЖИ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө	Жилд 1 удаа
		Цусны даралт үзэх	Жилд 1 удаа
		Холестерол илрүүлэх	5 жилд 1 удаа
		Чихрийн шижин	3 жилд 1 удаа
		Элэгний В, С вирус илрүүлэх	2 жилд 1 удаа
		Мэдрэхүйн эрхтний үзлэг	5 жилд 1 удаа
	Эм	Умайн хүзүүний өмөн	3 жилд 1 удаа
30-39 нас	Эр, эм	Цусны даралт, бие махбодийн үзүүлэлт, БЖИ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө	Жил бүр
		Цусны даралт үзэх	Жилд 2 удаа
		Холестерол илрүүлэх	3 жилд 1 удаа
		Чихрийн шижин	3 жилд 1 удаа
		Элэгний В, С вирус илрүүлэх	2 жилд 1 удаа
		Мэдрэхүйн эрхтний үзлэг	5 жилд 1 удаа
	Эм	Умайн хүзүүний өмөн	3 жилд 1 удаа
40-49 нас	Эр, эм	Цусны даралт, бие махбодийн үзүүлэлт, БЖИ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө	Жилд 1 удаа
		Цусны даралт үзэх	Жилд 2 удаа
		Холестерол илрүүлэх	Жилд 1 удаа
		Чихрийн шижин 2-р хэв шинж	3 жилд 1 удаа
		Элэгний В, С вирус илрүүлэх	2 жилд 1 удаа
		Мэдрэхүйн эрхтний үзлэг	5 жилд 1 удаа
		Ясны сийрэгжилт	3 жилд 1 удаа
	Эм	Умайн хүзүүний өмөн	3 жилд 1 удаа
50-64 нас	Эр, эм	Хөхний хавдар	Жилд 1 удаа
		Эр	Төмсөг болон түрүү булчирхайн хавдар
	Эр, эм	Цусны даралт, бие махбодийн үзүүлэлт, БЖИ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө	3 жилд 1 удаа
		Цусны даралт үзэх	Жилд 1 удаа
		Холестерол илрүүлэх	Жилд 4 удаа
		Чихрийн шижин 2-р хэв шинж	Жилд 1 удаа
		Элэгний В, С вирус илрүүлэх	2 жилд 1 удаа
		Мэдрэхүйн эрхтний үзлэг	2 жилд 1 удаа
		Ясны сийрэгжилт	5 жилд 1 удаа
			2 жилд 1 удаа

	Эм	Бүдүүн гэдэсний хавдрын шинжилгээ	3 жилд 1 удаа
		Уушгины хавдрын шинжилгээ	3 жилд 1 удаа
		Умайн хүзүүний өмөн	3 жилд 1 удаа
		Хөхний хавдар	Жилд 1 удаа
	Эр	Төмсөг болон түрүү булчирхайн хавдар	3 жилд 1 удаа
65-аас дээш нас	Эр, эм	Цусны даралт, бие махбодийн үзүүлэлт, БЖИ, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө	Жилд 1 удаа
		Цусны даралт үзэх	Жилд 4 удаа
		Холестерол илрүүлэх	Жилд 1 удаа
		Чихрийн шижин 2-р хэв шинж	2 жилд 1 удаа
		Элэгний В, С вирус илрүүлэх	2 жилд 1 удаа
		Мэдрэхүйн эрхтний үзлэг	5 жилд 1 удаа
		Ясны сийрэгжилт	2 жилд 1 удаа
		Уушгины хавдрын шинжилгээ	3 жилд 1 удаа
		Бүдүүн гэдэсний хавдрын шинжилгээ	3 жилд 1 удаа
	Эм	Умайн хүзүүний өмөн	3 жилд 1 удаа
		Хөхний хавдар	Жилд 1 удаа
	Эр	Төмсөг болон түрүү булчирхайн хавдар	3 жилд 1 удаа